

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/С49

Номгон

Баянхонгор аймгийн усны цахим
мэдээллийн санг бий болгох тухай


Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.2.1, Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 126 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн Усны цахим мэдээллийн сангийн програмын хэрэглэгчийн шаардлагыг боловсруулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, гүйцэтгүүлэхийг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Хүрэлсүх)-д зөвшөөрсүгэй.

2.Баянхонгор аймгийн усны бүх мэдээллийг цахим мэдээллийн санд оруулж, хэрэгжилтийг хангаж 2021 оны 12 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Хүрэлсүх)-д даалгасугай.

3.Усны цахим мэдээллийн сангийн програм, Домэйн нэрний төлбөр, жилийн үйлчилгээний төлбөр, нийт 7.000.000 (долоон сая) төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210513